



САНГИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Татварын ерөнхий хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авах журам”-ыг 1 дүгээр, “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан тухай тэмдэглэл”-ийн загварыг 2 дугаар, “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан ажиллагааг цуцлах тэмдэглэл”-ийн загварыг 3 дугаар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан “Татварын албаны мэдэгдэл”-ийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т даалгасугай.

САНГИЙН САЙД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Ц.НЯМДОРЖ

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Татварын ерөнхий хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д заасны дагуу татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө татвар төлөгчид сануулах байдлаар хөдөлгөөнийг хязгаарлах /цаашид “хөдөлгөөн хязгаарлах” гэх/ арга хэмжээ авах харилцааг зохицуулахад оршино.

1.2.Автотээврийн хэрэгсэл гэж “Автотээврийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг ойлгоно.

Хоёр.Хөдөлгөөнийг хязгаарлах үйл ажиллагаа

2.1.Татварын алба татвар төлөгчид Татварын ерөнхий хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу татварын нэхэмжлэх хүргүүлж, татвар төлөгч уг нэхэмжлэхэд заасан хугацаанд татвараа төлөөгүй тохиолдолд хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.Татварын ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.4-т заасны дагуу хөрөнгийн байдлыг тогтоож, татварын өртэй татвар төлөгчийн эзэмшилд бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлана.

2.3.Татварын улсын байцаагч, татвар хураагч /цаашид “татварын улсын байцаагч” гэх/ нь ажлын цагтаа багтаан албан татвар, төлбөрөөр 10 сая хүртэл төгрөгийн өртэй татвар төлөгчийн автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ажлын 5 хүртэл хоногийн хугацаатай хязгаарлах арга хэмжээ авна.

2.4.Хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

2.4.1.автотээврийн хэрэгсэл түүний эд ангийн бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж гадна талаас харагдахуйц гэмтэл, сэв, тухайн орчны зургийг авч хөдөлгөөнийг хязгаарласан тухай тэмдэглэлд бичиж баталгаажуулах;

2.4.2.автотээврийн хэрэгслийн дотор, ачаа тээшний хэсэгт түргэн муудах, хөлдөх бараа, хүнсний бүтээгдэхүүн, бусад бараа материал, үнэт эдлэл, зорчигч байгаа эсэхийг шалгах;

2.4.3.автотээврийн хэрэгслийн цонх, хаалга, тээшний хэсгийн цоож, дохиоллын бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалгах;

2.4.4.хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг замын хөдөлгөөнд саад учруулахааргүй байршуулсан эсэхэд татварын улсын байцаагч тухайн нөхцөл байдалд үнэлэлт өгч зориулалтын зогсоол, талбайд шилжүүлэх;

2.4.5.хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг хийхдээ зориулалтын дугуй түгжигч, эсхүл салхины шилний хаалт ашиглах бөгөөд “Татварын албаны мэдэгдэл”-ийг уг автотээврийн хэрэгслийн шилэн дээр харагдахуйц газар байрлуулах.

2.5.Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахдаа өртэй татвар төлөгч болон тухайн автотээврийн хэрэгслийг эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдийн төлөөллийг байлцуулна.

2.6.Хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг давтан хийж болно.

2.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний болон ажилчин, хүүхэд тээвэрлэдэг нийтийн тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөнд саад учруулахаар байршсан, хүйтний улиралд ил зогсоолд байгаа, автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хянах орчин муу газарт байрлах автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахыг тус тус хориглоно.

Гурав.Татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичиг

3.1.“Татварын албаны мэдэгдэл”-ийг автотээврийн хэрэгслийн шилэн дээр харагдахуйц газарт нааж гэрэл зургаар баталгаажуулан хөдөлгөөнийг хязгаарласан тухай тэмдэглэл /цаашид “Хөдөлгөөнийг хязгаарласан тухай тэмдэглэл” гэх/-ийг 2 хувь үйлдэн 1 хувийг авто тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн төлөөлөлд, нөгөө хувийг татварын улсын байцаагч өөртөө үлдээнэ.

3.2.“Татварын албаны мэдэгдэл”-д тухайн автотээврийн хэрэгслийг хөдөлгөх, шилжүүлэх зэрэг үйлдэл хийхийг хориглосон тухай мэдэгдэл, тээврийн хэрэгслийн улсын дугаарыг тусгаж, хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авсан татварын улсын байцаагчийн нэр, гарын үсгээ зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.3.Хөдөлгөөнийг хязгаарлах үеийн автотээврийн хэрэгслийн байдлыг өртэй татвар төлөгчид нэг бүрчлэн танилцуулан тэмдэглэлд тусгаж гарын үсэг зуруулна.

3.4.Хөдөлгөөнийг хязгаарласан тухай тэмдэглэл нь татварын албаны “Бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгэгдэж улсын хэмжээнд нэгдсэн нэг дугаартай байна.

3.5.Татварын улсын байцаагч нь “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг цуцалсан тухай тэмдэглэл” /цаашид “Цуцалсан тухай тэмдэглэл” гэх/-ийг 2 хувь үйлдэн 1 хувийг автотээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн төлөөлөлд өгч, нөгөө хувийг татварын улсын байцаагч өөртөө үлдээнэ.

Дөрөв.Хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг цуцлах

4.1.Өртэй татвар төлөгч ажлын цаг дуусахаас өмнө албан татвар, төлбөрөө бүрэн төлж барагдуулсан бол тухайн өдөр, ажлын цаг дууссан бол дараагийн ажлын өдөрт багтаан салхины шилний хаалт, дугуй түгжигчийг авна.

4.2.Татварын албанаас өр барагдуулах ажиллагаа хийгдэж эхэлсэн бол хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг цуцалж “Цуцалсан тухай тэмдэглэл”-д энэ талаар дэлгэрэнгүй тайлбар бичнэ.

4.3.Энэ журмын 2.3-т зааснаар хөдөлгөөнийг хязгаарлах хугацаа дууссан тохиолдолд татварын улсын байцаагч “Цуцалсан тухай тэмдэглэл”-д энэ талаар дэлгэрэнгүй тайлбар бичиж хөдөлгөөн хязгаарласан арга хэмжээг дуусгана.

Тав.Бусад

5.1.Хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ аваагүй нь татварын өр барагдуулах дараагийн арга хэмжээ авахгүй байх үндэслэл болохгүй.

5.2.Хөдөлгөөнийг хязгаарласан үед автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг өртэй татвар төлөгч хариуцна. Татварын албаны зөвшөөрөлгүйгээр дугуй түгжигч, салхины шилний хаалт, татварын албаны мэдэгдэл бүхий наалт тэмдгийг авах, автотээврийн хэрэгслийг хүчээр хөдөлгөхийг хориглоно.

5.3.Хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авсан төхөөрөмжийг эвдэх, гэмтээх тохиолдолд буруутай этгээдээр хохирлыг барагдуулна.

Маягт

Огноо: | | | | | | | | |

| | | _____

 | | | | | | | | | | | |
 | | | | | | | | | |

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Татварын улсын (ахлах) байцаагч: / /
 гарын үсэг нэр



Маягт

Огноо: | | | | | | | |

[illegible]

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Татварын улсын (ахлах) байцаагч: / /
гарын үсэг нэр





Монголын Татварын Алба

Маягт

ТАТВАРЫН АЛБАНЫ МЭДЭГДЭЛ

Татварын ерөнхий хуулийн 71-р зүйлийн 71.1-д заасан үндэслэлээр энэхүү
автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлан дугуй түгжих арга хэмжээг авав.

Иймд энэхүү автотээврийн хэрэгслийг хөдөлгөх болон шилжүүлэх зэрэг үйлдэл хийхийг
хориглоно. Мөн энэхүү автотээврийн хэрэгслийн үнэ цэнийг бууруулах аливаа үйлдэл
хийх эсхүл татварын албаны мэдэгдлийг хуулж авахыг хориглоно.

Тэмдэглэл

Хөдөлгөөнийг хязгаарласан тээврийн хэрэгсэл:

Автомашин (Улсын дугаар:)

20....оны ... дугаар сарын ... өдөр

..... татварын алба

Татварын улсын (ахлах) байцаагч: / /
гарын үсэг, тэмдэг нэр

